



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/125

Бат-Өлзий сум

Төрийн үйлчилгээний түц буюу киоск машин
хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавралтаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.3.8, 9.12 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Засаг даргын Тамгын газрын төрийн үйлчилгээний түц буюу киоск машин хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)
Гишүүд: Г.Доржханд (Хууль, эрх зүйн мэргэжилтэн)
Ө.Гөлгөө (Улсын бүртгэгч)
Б.Орбиш (Нийгмийн ажилтан)
Г.Бүд (Засаг даргын тамгын газрын нярав)

2. Захиалагчийн техникийн тодорхойлолт, шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа байдлыг хянан үзэж, гэрээний шаардлагыг биелүүлсэн нөхцөлд акт үйлдэн хүлээн авахыг ажлын хэсэг (Н.Бат-Эрдэнэ)-д, хөрөнгийг байгууллагын өмчийн бүртгэлд бүртгэхийг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдан авсан нэг цэгийн үйлчилгээний киоск машины ашиглалт, хамгаалалтад байнгын хяналт тавьж ажиллахыг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга (Э.Дашдулам)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН